



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/136/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан Утас:99459831, Цахим хаяг: shurtkhairkhaniikhishigaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5.1Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв	8
2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН
4-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

2026.02.25 № УВА-2026/130/АА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050500

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>220,808,469.70</u>	<u>139,729,430.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,955,262.70	18,659,470.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	110,955,262.70	18,659,470.16
3121	Төгрөг	110,955,262.70	18,659,470.16
31211	Төрийн сангийн харилцах	110,955,262.70	18,659,470.16
35	БАРАА МАТЕРИАЛ	109,853,207.00	121,069,960.00
354	Хангамжийн материал	109,853,207.00	121,069,960.00
35420	Аж ахуйн материал	00.00	824,750.00
35440	Түлш, шатах тослох материал	5,842,000.00	6,600,000.00
35460	Хүнсний материал	14,289,247.00	8,250,150.00
35470	Бусад хангамжийн материал	89,721,960.00	105,395,060.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>975,220,635.70</u>	<u>954,296,884.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	975,220,635.70	954,296,884.61
392	Биет хөрөнгө	824,788,635.70	803,864,884.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	821,303,201.00	821,303,201.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,688,182.01	-103,720,441.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	172,175,880.00	186,798,080.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-97,441,655.74	-116,312,637.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,713,532.86	43,088,532.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,094,032.01	-35,369,241.27
39217	Ном	7,819,891.60	8,077,391.60
393	Биет бус хөрөнгө	150,432,000.00	150,432,000.00
39301	Програм хангамж	517,500.00	517,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-517,500.00	-517,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	150,432,000.00	150,432,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,196,029,105.40</u>	<u>1,094,026,314.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,247,835.70</u>	<u>11,967,848.39</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,247,835.70	11,967,848.39
413	Өглөг	4,247,835.70	11,967,848.39
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,247,835.70	11,967,848.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,191,781,269.70</u>	<u>1,082,058,466.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,191,781,269.70	1,082,058,466.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258,628,636.20	258,628,636.20
51101	Өмч: - төрийн	258,628,636.20	258,628,636.20
512	Хуримтлагдсан үр дүн	879,624,475.17	769,901,671.85
51210	Өмнөх үеийн үр дүн	879,624,475.17	879,624,475.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-109,722,803.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	53,528,158.33	53,528,158.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,196,029,105.40</u>	<u>1,094,026,314.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,224,772,000.00	1,232,483,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,520,000.00	7,114,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,520,000.00	7,114,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	6,799,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	315,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,220,252,000.00	1,225,369,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,163,217,200.00	1,155,528,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,163,217,200.00	1,155,528,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,034,800.00	69,841,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,034,800.00	69,841,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,173,925,782.75	1,342,206,303.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,173,925,782.75	1,342,206,303.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,999,416.60	1,328,945,621.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,163,619.10	987,180,182.43
210101	Үндсэн цалин	532,849,872.68	607,223,810.26
210102	Нэмэгдэл	247,625,146.42	271,928,101.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,397,300.00	40,977,600.00
210104	Урамшуулал	51,291,300.00	67,050,670.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,946,900.00	121,052,700.80
210201	Тэтгэврийн даатгал	72,221,820.56	82,127,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,253,177.70	9,731,300.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,244,838.42	4,865,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,020,342.33	4,865,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,206,720.99	19,462,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,564,427.85	62,076,318.26
210301	Гэрэл, цахилгаан	12,361,427.85	16,402,818.26
210302	Түлш, халаалт	31,665,500.00	36,787,500.00
210303	Цэвэр, бохир ус	4,537,500.00	8,886,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,356,511.00	10,548,000.00
210401	Бичиг хэрэг	4,063,101.00	4,706,500.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,164,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	440,000.00	880,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,955,810.00	3,796,750.00
210408	Бараа материал акталсны зардал	4,897,600.00	00.00
2105	Нормативт зардал	94,129,444.00	99,114,369.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	90,000.00
210502	Хоол, хүнс	94,129,444.00	99,024,369.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	4,024,300.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	4,024,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,520,000.00	1,300,000.00
210702	Дотоод албан томилолт	2,520,000.00	1,300,000.00

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,547,150.00	6,605,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,150.00	4,737,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,099,000.00	1,868,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,271,364.65	37,044,451.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,439,802.32	866,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,780,800.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,050,762.33	36,178,451.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,926,366.15	13,260,681.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,797,994.00	8,503,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,797,994.00	8,503,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	128,372.15	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,756,881.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,756,881.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	50,846,217.25	-109,722,803.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	50,846,217.25	-109,722,803.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,220,252,000.00	1,225,369,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,220,252,000.00	1,225,369,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,163,217,200.00	1,155,528,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,163,217,200.00	1,155,528,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,034,800.00	69,841,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,034,800.00	69,841,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,146,027,161.72	1,309,209,592.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,146,027,161.72	1,309,209,592.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,100,795.57	1,295,948,910.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	838,915,783.40	979,460,170.54
210101	Үндсэн цалин	528,602,036.98	599,503,798.37
210102	Нэмэгдэл	247,625,146.42	271,928,101.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,397,300.00	40,977,600.00
210104	Урамшуулал	51,291,300.00	67,050,670.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,946,900.00	121,052,700.00
210201	Тэтгэврийн даатгал	72,221,820.56	82,127,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,253,177.70	9,731,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,244,838.42	4,865,600.00

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	4,020,342.33	4,865,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,206,720.99	19,462,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,406,427.85	62,834,318.26
210301	Гэрэл, цахилгаан	12,361,427.85	16,402,818.26
210302	Түлш, халаалт	37,507,500.00	37,545,500.00
210303	Цэвэр, бохир ус	4,537,500.00	8,886,000.00
2105	Нормативт зардал	96,037,571.00	92,985,222.00
210502	Хоол, хүнс	96,037,571.00	92,985,222.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,250,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,099,000.00	1,988,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,099,000.00	1,988,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,195,113.32	35,378,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,296,412.32	26,622,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,898,701.00	8,755,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,926,366.15	13,260,681.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,797,994.00	8,503,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,797,994.00	8,503,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	128,372.15	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,756,881.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,756,881.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	74,224,838.28	-83,840,092.54
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,680,000.00	8,455,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,680,000.00	8,455,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,680,000.00	8,455,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,680,000.00	8,455,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,680,000.00	-8,455,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	59,544,838.28	-92,295,792.54
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,410,424.42	110,955,262.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,955,262.70	18,659,470.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	258,628,636.20	53,528,158.33	697,771,270.30	1,009,928,064.83
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,628,636.20	53,528,158.33	697,771,270.30	1,009,928,064.83
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	39,171,955.70	39,171,955.70
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,628,636.20	53,528,158.33	879,624,475.17	1,191,781,269.70
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	258,628,636.20	53,528,158.33	879,624,475.17	1,191,781,269.70
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,628,636.20	53,528,158.33	879,624,475.17	1,191,781,269.70
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-109,722,803.32	-109,722,803.32
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,628,636.20	53,528,158.33	769,901,671.85	1,082,058,466.38

2.5.1. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗӨРҮҮ	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,257,557,500.00	1,247,824,092.54	9,733,407.46	99.2
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,257,557,500.00	1,247,824,092.54	9,733,407.46	99.2
Бараа, үйлчилгээний зардал	1,249,053,700.00	1,239,320,292.54	9,733,407.46	99.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	982,944,100.00	979,460,170.54	3,483,929.46	99.6
Үндсэн цалин	655,343,500.00	599,503,798.37	55,839,701.63	91.5
Нэмэгдэл	285,944,900.00	271,928,101.63	14,016,798.37	95.1
Унаа, болон бусад нөхөн олговор	-	40,977,600.00	(40,977,600.00)	-
Урамшуулал	41,655,700.00	67,050,670.54	(25,394,970.54)	161.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,280,400.00	121,052,700.00	1,227,700.00	99.0
Тэтгэврийн даатгал	82,962,600.00	82,127,800.00	834,800.00	99.0
Тэтгэмжийн даатгал	9,829,500.00	9,731,300.00	98,200.00	99.0
ҮОМШӨ ний даатгал	4,914,700.00	4,865,600.00	49,100.00	99.0
Ажилгүйдлийн даатгал	4,914,700.00	4,865,600.00	49,100.00	99.0
Эрүүл мэндийн даатгал	19,658,900.00	19,462,400.00	196,500.00	99.0
Нормативт зардал	97,740,800.00	92,985,222.00	4,755,578.00	95.1

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоол, хүнс	97,740,800.00	92,985,222.00	4,755,578.00	95.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,739,400.00	4,717,000.00	22,400.00	99.5
Мэдээллийн технологийн зардал	4,739,400.00	4,717,000.00	22,400.00	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	41,349,000.00	41,105,200.00	243,800.00	99.4
Бараа үйлчилгээний бусад зардал	32,593,000.00	32,349,500.00	243,500.00	99.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,756,000.00	8,755,700.00	300.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,503,800.00	8,503,800.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	8,503,800.00	8,503,800.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	8,503,800.00	8,503,800.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,240,135,400.00	1,155,528,300.00	84,607,100.00	93.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,240,135,400.00	1,155,528,300.00	84,607,100.00	93.2
Улсын төсвөөс санхүүжих	1,240,135,400.00	1,155,528,300.00	84,607,100.00	93.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	110,955,262.70		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,659,470.16		-

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗӨРҮҮ	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,841,200.00	65,084,318.26	4,756,881.74	100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	69,841,200.00	65,084,318.26	4,756,881.74	100.00
Бараа, үйлчилгээний зардал	69,841,200.00	65,084,318.26	4,756,881.74	93.19
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,591,200.00	62,834,318.26	4,756,881.74	92.96
Гэрэл цахилгаан	18,568,300.00	15,143,241.04	3,425,058.96	81.55
Түлш, халаалт	32,802,200.00	38,805,077.22	(6,002,877.22)	118.30
Цэвэр, бохир ус	16,220,700.00	8,886,000.00	7,334,700.00	54.78
Эд хогшил худалдан авах	2,250,000.00	2,250,000.00	-	100.00
Урсгал засвар	2,250,000.00	2,250,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,841,200.00	65,084,318.26	4,756,881.74	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,841,200.00	65,084,318.26	4,756,881.74	100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -орон нутаг	69,841,200.00	65,084,318.26	4,756,881.74	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэг нь нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх зорилготой байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,002.7 мянган төгрөг буюу 8,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,955.2	18,659.5	-92,295.7
АВЛАГА			0.0
УРЬДЧИЛГАА			0.0
БАРАА МАТЕРИАЛ	109,853.2	121,069.9	11,216.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	975,220.6	954,296.9	-20,923.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,196,029.0	1,094,026.3	-102,002.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,247.8	11,967.8	7,720.0
Засгийн газрын хувь оролцоо	1,191,781.2	1,082,058.5	-109,722.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,196,029.0	1,094,026.3	-102,002.7

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,659.5 мянган төгрөг болж буурсан нь харилцах дансны үлдэгдлээс зарцуулалт хийсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 121,069.9 мянга төгрөг болж, 11,216.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд аж ахуйн материал 824.7 мянга, бусад хангамжийн материал 15,673.1 мянга, шатах тослох материал 758.0 мянган төгрөгөөр нэмэгдэж хүнсний материал 6,039.1 мянга төгрөг тус тус материалын эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 954,296.9 мянган төгрөг болж 20,923.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тоног төхөөрөмж 14,622.2 мянга төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил 375.0 мянга, номын фонд 257.5 мянган төгрөгөөр, элэгдлийн зардал 36,178.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,094,026.3 мянган төгрөг болж 102,002.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,022,578.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 80,140.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,240,135.4 мянга, орон нутгийн төсвөөс 69,831.2 мянга, нийт 1,309,966.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн хүрээнд 40 арга хэмжээнд 1,240,135.4 мянган төгрөг улсын төсвөөс, 69,831.2 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,155,528.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 69,841.2 мянган төгрөг нийт 1,225,369.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт урсгал үйл ажиллагаанд 1,220,612.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,220,612.7 мянган төгрөг буюу 108.0 хувьтай байгаа нь урьд оны үлдэгдлээс 92,295.7 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Улсын төсөв/ /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	Биелэлтийн хувь
	Код	НЭР				
1	80233	Хүүхэд хамгаалал	2125.6	2124.2	-1.4	99.9
2	81605	Эрүүл мэндийг дэмжих	1952.3	1952.3	0	100.0
3	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	94626.1	92985.2	-1640.9	98.3
4	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4009.3	4006.6	-2.7	99.9
5	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1723.4	1,485.0	-238.4	86.2
6	81834	Боловсролын стандарт, сургалт	1,004,322.00	1,108,136.20	103814.2	110.3
7	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	46,769.60	37,134.60	-9635	79.4
Дүн			1,155,528.30	1,247,824.10	92,295.80	108.0

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Орон нутгийн төсөв/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	биелэлтийн хувь
	Код	НЭР				
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	69,841.20	65,084.30	-4,756.90	93.2
Дүн			69,841.20	65,084.30	-4,756.90	93.2

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл, тайлагнал	0	0	Тайлант онд программ худалдан аваагүй байна.
2	Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф	285,944.9	40,977.6	Төрийн албаны тухай хуулийн 61.1.3 Монгол улсын засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 6 дугаар тогтоол
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	0	0	Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна.

**Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0	0	Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0	0	Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0	0	Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0	0	Байгуулсан гэрээ болон зардал гараагүй болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэг тайлант онд хүнсний материал худалдан авахад тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 97,740.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,342,206.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,422.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 10,737.6 мянган төгрөгөөр тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэг нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэг нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс 163 мэдээллийг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон 5 мэдээлэл, мэдээлээгүй 3 шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,477.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

5.1. Төлбөрийн акт

1. Улаангом сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч Ж.Долгосүрэн, нягтлан бодогч М.Лхагвасүрэн нарт ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож нийт 3,477.2 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улаангом сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч Ж.Долгосүрэн, нягтлан бодогч М.Лхагвасүрэн нарт ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож нийт 3,477.2 мянган төгрөгийн ээлжийн	1	3,477.2	1	3,477.2								

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Улаангом сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

амралтын цалинг илүү олгосон байна.													
Дүн	1	3,477.2	1	3,477.2									

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Нийт дүн													

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ” ХХК-ийн АУДИТОР

/С.БАТСАЙХАН/

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/10/В2915686
УВА-2026/136/НА-СТА-ТШЗ

Улаангом

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаангом сумын 4-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаангом сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч Ж.Долгосүрэн, нягтлан бодогч М.Лхагвасүрэн нарт ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож нийт 3,477.2 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон ээлжийн амралтын цалин 3,477,171 (гурван сая дөрвөн зуун далан долоон мянга нэг зуун далан нэг) төгрөгийг төлүүлж, Төрийн сан дахь МХГ-ын орлогын 1000150000982 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Увс аймгийн Боловсролын газрын дарга А.Болормаад хариуцуулав.

¹ Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

8525110046

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөргүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТОССОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН

“ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ” ХХК-ийн
АУДИТОР

 С.БАТСАЙХАН

